



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 06 өдөр

Дугаар А/МТ

Булган сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1.6 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX хуралдааны “Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай” 19/08 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2024 оны А/32 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг угтан аймаг орон нутгийн зүгээс олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг зохион байгуулах ажлын хүрээнд малчин эмэгтэйчүүд болон зорилтот өрхийн иргэдэд чиглэсэн “Дулаан сэтгэл” хандивын тоглолтыг зохион байгуулсугай.

2. Хандивын тоглолт зохион байгуулахад шаардагдах 500,000 (таван зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын жендэрийн эрх тэгш байдлыг хангах хуулийг хэрэгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөө хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

3. Малчин эмэгтэйчүүд болон зорилтот өрхийн иргэдэд чиглэсэн “Дулаан сэтгэл” хандивын тоглолтыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (М.Батчимэг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



БАРИУН-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 2024 оны
03. дугаар сарын 06-ны өдрийн А. /Н.А. дугаар
захирамжийн хавсралт

ОЛОН УЛСЫН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ӨДРИЙГ
УГТАН "ХАРИЛЦАН ХҮНДЭТГЭЭ" САРЫН АЯНЫ ХҮРЭЭНД
ЗОХИОН БАЙГУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСӨВ

Д/д	Шаардагдах зардал	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	2	3	4	5
1.	Шууд нэвтрүүлэг бэлтгэх зардал	1	500,000	500,000
	Нийт		500,000 төгрөг	